

ЗАНАБАЗАРЫН УРЛАГ БА ДУНДАД ЗУУНЫ ХОЖУУ ҮЕИЙН МОНГОЛД
БҮДДИЙН ШАШИНТ УЛС БАЙГУУЛСАН НЬ

Ц.Уранчимэг¹

Анхдугаар Жавзундамба хутагт Өндөр Гэгээн Занабазар (1635-1723) нь Монголын Бурхан шашны түүхэнд онцгой байр суурь эзлэдэг төдийгүй Монголын улс төр, түүх, нийгэм, соёлын амьдралын чухал үеүдэд ул мөрөө үлдээж, монголчуудын хувьд шинэ эрин үеийн эхлэлийг тавьсан хүн билээ. Түүний бүтээл хэмээн бидний мэдэх бурхадын баримал нь бурхан дүрслэлийн дэг жаяг, төгс төгөлдөр уран нарийн хийцийг гайхамшигт сэтгэлгээтэй хослуулсны дээд илэрхийлэл юм.

Занабазарын амьд ахуйд түүний шавь эрдэмтэн Зая Бандид Лувсанпэрэнлэйн (1642-1715) бичсэн шаштир нь² Занабазарын намтруудаас үлдсэн хамгийн чухал бөгөөд үнэмшилтэй эх сурвалж гэж эрдэмтэд үздэг.³ Занабазар нь 1635 оны 9 дүгээр сарын 25-ны өлзий учрал бүрдсэн сайн өдрийн өглөө Түшээт Хан Гомбодоржийн (1594-1655) хоёрдугаар хүү болон мэндэлжээ хэмээн Лувсанпэрэнлэй бичжээ. Түүний эцэг Түшээт Хан Гомбодорж болон эх Ханджамц нар монголын их хаадын алтан ургийнхан бөгөөд Лувсанпэрэнлэй багшийнхаа намтраа Занабазарын сурвалжит удам угсааны хэлхээсээр эхлүүлсэн байдаг.

Занабазар хүүхэд ахуй цагаасаа олон төрлийн авъяастай нэгэн байжээ. 3 настайдаа Манзушир бурхны эртний судруудын нэг болох “Манзуширийн алдрыг өгүүлэхүй” (Manjusrinamasangiti), сударыг цээжээрээ уншиж чаддаг байсан гэнэ. Энэ судрыг Алтан Хааны /1507-1582/ ач Чойжамц 4 хэлээр хөрвүүлж 1502 онд хэвлүүлэн гаргасан гэдэг⁴. Тэрбээр 4 настайдаа Занабазар хэмээх (Төвдөөр: Yeshe rdo rje) номын нэртэй болж, Жамбалын Номын-Ханаас бурхны шашны анхан шатны зэрэг дэв болох гэнэн (Түвдөөр: dge bsnyen gyi sdom pa; Санскритаар: upasaka samvara) санваар хүртжээ. Түүнийг таван настай байхад нь Ширээт Цагаан нуур хэмээх газар Халх Монголын Бурхан шашны тэргүүнээр өргөмжлөн, сахил санваарын хэргэм зэрэг болох Лувсандамбийжалцан (Blo bzang bstan pa'i rgyal mtshan) хэмээх номын хоёр дахь нэр хүртээжээ.⁵

Занабазар эхний удаа 1649-1651 онд, дараа нь 1655-1656 онд хоёр удаа Түвдэд аялсан билээ. Тэр үед 5 дугаар Далай Лам /1617-1682/ болон 4 дүгээр Ванчин Богд /1569-1662/ нар

1. Монгол Улсын Их Сургууль

2. Зая Бандид Лувсанпэрэнлэй нь Монголын нэрт бурхны шашин судлаач эрдэмтэн байв. Түүний тухай хоёр судар байдаг бөгөөд нэгийг нь тэр өөрөө, хоёр дахийг нь түүний шавь Ганжуур Мэргэн Номын Хан бичсэн байдаг. Ш. Бира 1995: 5-6.

3. Н. Цүлтэм 1982а: 80-85.

4. Ш. Бира 1995:27.

5. Н. Цүлтэм Занабазар: Монголын уран барималч (Улаанбаатар 1982), Patricia Berger “Zanabazar” in Berger and Bartholomew 1995: 261-263.

Ц.Уранчимэг

Занабазарыг төрөхөөс нэг жилийн өмнө жанч халсан Жонанпа сургуулийн түүхч Дарнатын /1575-1634/ хувилгаан болохыг таниж мэдсэн тухай Монгол эх сурвалжуудад бичсэн байдаг⁶. Жавзундамба хутагт Гумбум болон Амдогоор дамжин аялж. Түвдийн төв хэсэг болох Үй, Занд нэлээд хугацаагаар амьдрах үед Гэлүгва ёсын (dGe lugs) хийдүүдэд бараалхан шавилж байсан хэмээн шаштирт онцгойлон дурьдсан нь олонтой.

Занабазар нь Далай лам, Ванчин Богд нартай 1650 онд уулзсан гэдэг бөгөөд Гэлүгва ёсын дэг сургуультай ойр холбоотой байсан хэмээн намтруудад онцгойлсон нь анхаарал татна. 5-р Далай лам нь Жавзун Дарнатын /1575-1634/ хойт дүр нь болохыг тодруулсан гэлтэй. Гэвч энэ мэдээлэл Түвдийн эх сурвалжуудад байхгүй байгааг харгалзан монгол сурвалжууд дахь эдгээр мэдээллийг дахин харж үзэх шаардлага гарч ирж байна⁷. Занабазарын багш нь 4-р Ванчин Богд байсан бөгөөд түүнд Ямандагийн эрхийн ван олгож Важравали номыг заасан гэдэг⁸. Өөрийн сурсан номын бурхад нь Занабазарын уран бүтээлд огт байдаггүй бөгөөд чухамхүү ямар бурхадыг ямар байдлаар бүтээж байсан нь тайлбарлагдаагүй орхигдсоор ирсэн учир энэ ажилд шинжлэн үзсэн гол асуудлуудын нэг болсон юм.

Өндөр Гэгээн Монголдоо эргэж ирээд Бүддийн шашны сүм хийд барьж эхлэн урлагийн бүтээлээ хийх үйлд шамдан оржээ. Занабазар бага залуу наснаасаа урлаг сонирхох болж 1647 онд 13 настай байхдаа анхлан Баруун Хүрээг байгуулсанаар энэхүү хийд нь одоо хүртэл байршлаа өөрчлөөгүй үлдсэн гэдэг⁹. Тэрбээр зөвхөн өөрийн Рибогежай-гандан-шадувилан хийдэд зориулан бүтээлээ урладаг төдийгүй 1680-1686 онд Чин гүрний эзэн хаанд болон Богд Зонхавын Амдо дахь багш Дондовринчин цоржийн (Chos rje don 'grub rin chen) үүсгэн байгуулсан хийд зэрэг олон сүм хийдүүдэд зориулан бурхадыг бүтээн урлаж байжээ. Тэрбээр уран барилгач, уран барималч, зураач байсан гэдгийг шаштир түүх баталдаг.

Занабазар Чин гүрний эзэн хааныхантай холбоотой байсан төдийгүй Эвээр Засагч хаанд (1644-1662) өөрийн урласан бурхны хөргийг 1655 онд бэлэг болгон илгээж байсан түүхтэй. Дараа нь Энх-Амгалан хаантай (1662-1722) холбоо тогтоож; түүнд бэлэг илгээж байсны дотор зурмал танга зураг, Манзушрийн судрын Тонва Тондэн бурхан (mthong ba don ldan)¹⁰ болон Бурхан багш Шакьямүнийн “гурван алтан хөрөг” (уран баримлын бүтээл бололтой) зэрэг бүтээлүүд дурьдагддаг¹¹. Өндөр Гэгээн Занабазар нь соёмбо үсгийн цагаан толгой зохиосон нь Түвд хэлний нэр томъёог монголчлон буулгахад амар хялбар болгосон гэлтэй. Тэрбээр Халхын улс төр, бурхны шашны тэргүүнээр хүлээн зөвшөөрөгдөх болж 1691 онд Халх Монгол Манжийн Чин улсад дагаар орох түүхэн шийдвэрийг гаргасан хэмээн түүхчид үздэг хэдий ч үүнийг дахин

6 Энэ мэдээллийг зөвхөн монгол эх сурвалжаас олж болох боловч Дарнатийн өөрийн намтарг байхгүй. <http://www.jonangpa.com/node/1445> хаягаар Michalel Sheeshy „Taranatha's Travels in Mongolia” - ийг үзнэ үү. Занабазарыг Дарнатын хувилгаанаар тодруулсаныг

хэн, хэзээ, хэрхэн тодруулав гэдэг нь судалгаа шаардсаар байна. Мөн дараах зохиолыг үз: Miyawaki Junko „How Legends Developed about the First Jebtsundamba: In reference to the Khalkha Mongol Submission to The Manchus in the Seventeenth Century”, Memoirs of the Research Department of the Toyo Bunko (1994/52), 50-53.

7. Junko 1994.

8. Лувсанпэрэнлэй, 8-10, Позднеев 1898: 327.

9. Баруун Хүрээ хийд XIX зууны сүүл үе шахтал оршин тогтнож байв. Энэ тухай Алексей Позднеев 1898 онд тодорхой

тайлбарласан болно.

10. Тонгва Дондэн Tongwa Donden (Mthong ba don ldan), Keith Dowman, The Power – places of Central Tibet: The Pilgrim's Guide, (London: Routledge & Kegan Paul, 1988)

11. Л. Хүрэлбаатар Анхдугаар Богд (Улаанбаатар, 2001), 100, 108. Лувсанпэрэнлэй: 120-121. Түүнчилэн Лувсанпэрэнлэй.

133, н. 55 болон Позднеев 1898: 328.

Ц.Уранчимэг

эргэн харах хэрэгтэй аж. Энэхүү шийдвэрийг Галдан бошигтын байнгын довтолгооноос үүдсэн дотоод хямралын үр дүнд гаргасан хэмээн үздэг¹². Чин улсын Энх-Амгалан хаантай холбоогоо цаашдаа зузаатгаж, 1691 оноос түүний насан эцэс болох хүртэл багш нь байсан бөгөөд тэд хамтдаа 1697 онд Утайд мөргөл хийхээр аялж байсан гэдэг¹³.

Язгуурын Таван Бурхан

Өндөр Гэгээн Занабазар нь 1680-аад онд уран бүтээлийн оргилдоо хүрч Язгуурын Таван Бурханыг туурвижээ (зураг 1-5). Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд Таван Бурханы 4 эх бүтээл нь хадгалагдаж буй. Тав дахь нь Раднасамбава (Ratnasambhava) буюу “Гайхамшигт төрөлт” Чойжин ламын сүм музейд бий. Таван Бурхан нь хэмжээний хувьд ижил ч чимэг зүүлт, титэм, дүр төрхөөрөө тус бүр ялгаатай¹⁴. Бурхан бүрийн дүр төрхийг хэе угалз, зүүлт чимэглэл зэргээр ялгаруулан тодотгожээ. Жишээ нь: Амогасиди (Amoghasiddhi) бурхны зүүлт нь түүний тэмдэг нацагдорж дүрстэй бол Акчоба бурхны гоёл нь түүний тэмдэг очир хэлбэр дүрстэй байна. Раднасамбава нь ялгуусан киртимух (kirtimukha) төрхт бүлтгэр чимэглэлээр бусад дөрвөөсөө ялгагдана. Ялгуусан төрхт амандаа сувдан зүйлт зууснаар дүрслэгддэг бол Өндөр Гэгээн өөр нэгэн энгийн байдлаар шийдсэн байна (зураг 3). Раднасамбава бурханы чимэглэлийг түүний тэмдэг радна (эрдэнэ) тодотгож байхад Амиитабагийн тэмдэг лянхуа цэцэг нь нөмрөг дээрхи түүний гол дүрслэл болж өгнө. Үсний сувдан чимэг нь бурхадыг амилуулан сэргээх мэт нарийн тодотгол болно. Язгуурын таван Бурхадыг зайнаас харахад ялгаа нь мэдрэгдэх боловч ойртон шинжвээс үлэмж баялаг хийц нь улмаар тодрон гүнзгийрэх мэт сэтгэгдэл төрүүлж үзэгчдийг өөрийн эрхгүй татна.

Занабазар уран баримлаа бүтээхдээ овор хэмжээг анхаарахын сацуу, хүний биеийн дүрсээр илэрхийлж буй бурхадын бие бялдын төгс сайхныг магтан дуулдаг нь мөн л бусдаас ялгарах онцлог билээ. Түвд бурхадын адилаар Энэтхэгийн Гупта үеийн хийц маягийг баримтлан, уруул, хөмсөг зэрэг нь Энэтхэгийн Пала үеийн урлагийн нөлөөг илтгэх боловч урлаг судлаач Марилин Рийгийн үзэж байгаагаар Занабазарын уран бүтээл хүний биеийн галбирыг харуулсанаараа тухайн үеийн Түвд болон Хятадын уламжлалаас ялгарч байгаа ажээ¹⁵. Түвд ба Хятадын уран барималууд голдуу өмсгөлтэй, заримдаа бие галбир нь олон давхар нөмрөгийн доор далдлагдсан байдаг бол Занабазар биеийн эрүүл чийрэг эрч хүч, эрчимт хөдөлгөөнийг харуулахыг чухалчилдаг нь нэн сонин¹⁶. Түүний бүтээсэн бурхад нь тансаг ур хийц, нарийн чимэглэл, чимхлүүр ажиллагаа бүхий агаад хүний биеийн төгс галбир, тэнцвэрт байдлыг гоёмсог харуулдаг.

Бирузана нь (зураг 1) Язгуурын Таван бурхадын төв хэсэгт байрлах бөгөөд түүний сүр жавхланг, гайхамшигт дүр төрх нь үнэхээрийн Бишрэл Төгс гэж хэлж болохоор. Бирузанагийн ээмэг, бугуйвч, бүс болон биеийн чимгүүд тод томруун дүрслэлтэй, энгэрийн зүүлт, нөмрөг зэргээр бусдаас ялгагдаж чимэггүй хэсэгт нь толигор арьстай, алтан шармал булчинлаг бие нь

12. Түшээт хан болон Занабазар нар Манжийн ордонд Галдангийн дайралтаас хамгаалах тусламж хайж явж байхдаа Манжийн

эзэн хаан Кангсид үнэнч байх танграг 1691 онд Долоон нуурт өргөсөн гэж Жунко үзжээ. op.cit.56.

13. Агван Лувсандондов, 56.

14. Язгуурын таван бурхад, David Snellgrove *Indo-Tibetan Buddhism: Indian Buddhists and their Tibetan Successors* (Boston, Shambhala Publications, 2002 [1987]), 189-198. Snellgrove язгуурын таван Бурханы эртний тариний ёсны

бясалгалын гол сургаал Sarvatathagatatattvasamgraha-д дүрсэлснээр тайлбарлажээ.

15. Монголын бурханы шашны тухай хурлын үеэр Марилин Рийгийн тавьсан илтгэл, Smith College, 2009 оны 3 дугаар сар.

16. Ibid.

маш хүчирхэг харагдана.

Язгуурын Таван Бурхан нь бурхадын ангилалын системд эртнээс төлөвшсөн язгуур бүлэг мөн. Бурхадыг эрэмбэ зэргийн дагуу ангилал тогтоох эртний оролдлого нь 7-р зууны Тан улсын үеийн (618-907) Дунхуаны хананы зургуудаас харагдах бөгөөд энэхүү Таван Бурхан нь хот мандалын цогц болон тарнийн бясалгалын үндэс болж өгнө. Ригсумгомбо буюу Лянхуа, Очир ба Будда зэргийн Язгуурын Гурван Бурхадын бүлэг (*kula*) дээр хожим Радна ба Нацагдоржийн бүлэгээр өргөжин тав болж Монголын урлагт эдгээрийг хот мандалын цогц хэлбэрээр зөвхөн Занабазар анхлан бүтээсэн нь тохиолдлын зүйл бусаа. Өндөр Гэгээн Язгуурын Таван Бурхан бүтээж Их хүрээнд Ригсумгомбо хийд байрлуулснаар тэрбээр Халх нутагтаа Очирт хөлгөний үндсийг тавьж тарнийн бясалгалыг хөгжүүлэх, үүгээрээ Буддийн шашны урьд өмнө Монголд нэвтрүүлж байсан байдлуудыг харьцуулахуйд Бурхан багшийн сургаалийг Монгол орноо үндэс суурьтай хөгжих нөхцөлийг бүрдүүлэхэд их анхаарч байсан нь байна. Ийм зохион байгуулалттай хандлага нь Түвдэд ба Чин улсын үеийн Хятадад буддийн шашны зохиол бүтээлүүдийг системчлэх аргуудтай төстэй. Тухайлбал, Бутон Ринчендовын (Bu ston Rin chen Grub 1290-1364) Буддын уран зохиолыг эмхэлж Тарнийн ёсыг 4 ангилалд хуваан тогтоосон бол Чин улсын Энх-Амгалан хаан бурхадын зураг чимэглэл бүхий Ганжуурыг монгол хэлээр Бээжинд 1717-1720 онд хэвлэн гаргасан нь шашны мэдлэгийг системчилэн олон түмэнд хүргэх чухал арга замууд байлаа. Эдгээрийн адилаар Өндөр Гэгээн маань ч гэсэн Халх Монголд дахь Буддийн шашны хожуу үеийн дэлгэрэлтийг ийнхүү үндэс суурьтай, нарийн зохион байгуулалттайгаар нэвтрүүлэхийг зорьсон бололтой. Бурхан багшийн номыг үндэс суурьтай нэвтрүүлэхдээ язгууртан дээдсийн хүрээнд дэлгэрүүлэхээс гадна жирийн энгийн ардууд ч мөн сурах, хамтаар болон хувиар мөргөлийн зан үйлийг дагах үүдийг нээж өгсөн билээ.

Тогоонтөмөр Хаан нь 1345 онд Бээжин хотын ойролцоо Жуйон хаалган дээр сийлсэн хот мандалын төвд Бирузана бурханыг залсны нэгэн адилаар¹⁷ Занабазар Очирын (Aksobhya) бүлгийг (*kula*) бус Татхагатын бүлгийг хот мандалын төвд залснаар Монголын Их гүрний өнгөрсөн үеийн уламжлалыг санагдуулах хэдий ч Занабазарын Бирузана нь Бодь Агри (*bodhi agro mudra*) буюу дээд гэгээрлийн барилаар мутраа чагжаалснаар Очир Язгууртны (*Vajradhatu*) Бирузана болох нь тодорхой. Үүгээр “Хамаг Бурхдын мөн чанарын хураангуй” (*Sarvatathagatatattvasamgraha*) хэмээх эртний тарнийн сургаалийг Монголд нэвтрүүлснийг тодорхой харуулж байна¹⁸. Занабазар Буддийн шашны номыг Монголд дахин дэлгэрүүлэхдээ ямар нэгэн дэг сургууль гэхээс илүү бүхий л ёсны дундаас Тарнийн ёсны сургалт болон бясалгалын үндэс болдог “Хамаг Бурхдын мөн чанарын хураангуй” (*Sarvatathagatatattvasamgraha*) сургаалийг голчилж байсан болохыг Таван Бурхадыг бүтээсэн түүний байдал илт нотлоно. “Хамаг Бурхдын мөн чанарын хураангуй” (*Sarvatathagatatattvasamgraha*) нь Бурхан багш Шакьяамунийн номлосон эртний сургаал болой.

Хэрэв Занабазар түүний урьд дүр болох Дарнатын уламжлалыг хадгалж Жонанпа урсгалд үнэнч байсан бол энэхүү урсгалын гол шүтээн болох Дуйнхор (*Kalacakra*) бурханы дүрийг бүтээх нь гарцаагүй. Хэрвээ Далай лам болон Ванчин богд нар Занабазарыг Гэлэгва ёсны суурь онолд сургасан аваас¹⁹ Сандуйн (Гухясамажа *Guhyasamaja*) ёсны дагуу хот мандалын төвд Акчоба (*Aksobhya*) буюу Очир бүлгийг залах байсан. Иймд Занабазар Бутон Ринпүче Тарнийн

17. Бергер, 2003: 56.

18. Snellgrove, 120-121: 197-198. Steven Weinberger *Sarvatathagatatattvasamgraha* гэсэн гарчигийг өөрөөр “Зарчмуудын

чуулга” гэж орчуулжээ. Steven Neal Weinberger, “Significance of Yoga Tantra and the Compendium of Principles (*Tattvasa graha*) within

Tantric Buddhism in India and Tibet” (Ph.D. Dissertation, University of Virginia, 2003). “Хамаг тэгчлэн ирэгсдийн мөн буюу чанарыг уряасан” гэж орчуулжээ

19. Позднеев 1898:328.

Ц.Уранчимэг

номыг 4 ангилсны Yoga ангилалын бясалгалын үндсэн язгуур судрыг сонгон авсан нь чухал учир утгатай бөгөөд алс ирээдүйг бодолцсон хандлагыг илтгэнэ.

Хорин нэгэн Дар Эх

Хорин нэгэн Дар Эх нь Занабазарын нийт уран бүтээлд гол байр суурь эзэлдэг (зураг 6). Занабазар 1706 онд Хорин нэгэн Дар Эхийг бүтээсэн болон Их хүрээнд Дар Эхийн сүм барьсан гэж Өндөр Гэгээний намтрыг 20-р зууны эхэнд бичсэн Дагважанцан дурджээ²⁰. Патрисия Бёргерийн үзэж буйгаар гайхамшигт Цагаан Дар Эхийн эх бүтээлийг анх Эрдэнэ Зуу хийдэд байрлуулж байгаад Их Хүрээний Дар Эхийн сүмд шилжүүлэн авчирчээ.²¹

Түүхээс харахад Ногоон Дар Эхийг гол шүтээнээр залж өөрсдийн амжилтыг түүнтэй холбон шүтэж байсан Зуу Атиша (Jowo Atiśa 982-1054) болон Анхдугаар Далай лам Гэндэндэв (Dge 'dun grub 1391-1475) нарын адилаар Занабазар 21 Дар Эхийг шүтэх болсон хэмээн Дагважанцан тайлбарласан байдаг²². Түвдэд Дар Эхийг өргөнөөр шүтэж байсан бөгөөд Дар Эхтэй холбоотой Түвдийн янз бүрийн үеийн эрдэмтдийн бичсэн олон тооны ном судар байсан талаар Дагважанцан бичсэн боловч Дарнатыг дурсаагүй хэрнээ харин Атиша, түүний шавь Дромтон (Brom ston 1005-1064), Богд Зонхова нарыг онцлон тэмдэглэсэн нь Гаадамба болон Гэлэгва сургуулийн үүднээс түүхийг бичсэнийг харуулна. Занабазар Их хүрээн дэх Дар Эхийн гол хийдүүдийг бүтээсэн бөгөөд бурхадын хийц маягийг шинжлэн үзэхэд зөвхөн Гэлэгва үзлийн дагуу тайлбарлаж болохгүй байгаа юм²³.

Хорин нэгэн Дар-Эх нь XI зууны сүүлээр Түвд хэлэнд орчуулагдсан Дар Эхийн судруудын хамгийн чухал нэгэн болох “Хорин нэгэн ерөөлийн магтаал” хэмээх зохиолоос гаралтай, үүнийг Түвдийн эрдэмтэд, ялангуяа Сажийн ёсны нэрт эрдэмтэн Дагважалцан (Grags pa rgyal mtshan, 1147-1216) нар судалж, дэлгэрэнгүй тайлбар бичсэн нь олонтой²⁴. 21 Дар-Эхийг бүтээхэд Суряагупта, Нагаржунай ба Атиша, Нингмагийн гэсэн гурван гол арга барилаар бүтээдэг уламжлалтай²⁵.

Занабазар нь эдгээр дүрслэлийн гурван арга барилтай Жонан Пунцаглин (Jo nang phun tshogs gling) хийдэд танилцсан байж болзошгүй боловч түүнийг Пунцаглинд очиход 21 Дар Эхийн бүтээл байсан эсэх, 1651 онд Занабазар Түвдээс буцаж ирэхдээ 21 Дар Эхийн бүтээл болон судар авч ирсэн эсэх нь тодорхойгүй байна.²⁶ Занабазар Түвдэд байх үедээ, мөн хожим 1690-ээд онд Түвдээс Данжуурын номыг Монголд залж авчирсан хойно ч Дар Эхийн тухай тайлбарыг

20. Дагважанцан Тийн Удирдагч Жавзундамбын их эрдэнийн намтар магтаалийн үг сайн хувьтны сүсэгийг сэргээгч оршвой (1912). Орчуулсан Ш. Сонинбаяр, Ш. Бира, Өндөр Гэгээний намтрууд оршвой. (Улаанбаатар, 1995), 41.

21. Хүрэлбаатар 2001: 174-175.

22. Дагважанцан, 40, Позднеев 1898: 337.

23. Martin Willson, In Praise of Tara: Songs to The Savoiress (London: Wisdom 1986), 289-299. Дарь Эх эртний Махаяна Mahayana

судруудад Manjusri-mula-kalpa болон Mahavairocana-tantra их хөлгөний сургаалд Жанрайсигтай холбоотой гардаг. Тарний ёсны гол сургаал “Бүх зан үйлийн сурвалжийн тухай” - д Дар Эх нь бүх Татхагатагийн эх гэжээ Энэхүү сургаалаас гадна Түвдийн судруудад Дар Эхийг Найман айдсаас ангижруулагч гэж сургадаг, Арьявал Дар Эхийн эрхэм хүндтэй 108 нэр болон хүндэтгэлийн 21 магтаал, Вилсон 1986.

24. Martin Willson, 1996 [1986], 107-166.

25. Beyer, S. (1996) Magic and Ritual In Tibet: The Cult of Tara (Delhi Matilal Banarsidas Publishers), 469-70, n.11. Willson, M. (1996 [1986]) In Praise of Tara: Songs to the Saviouress, (Boston, Wisdom Publications, 1986), 118-119.

26. Хүрэлбаатар 2001:65, Позднеев 1898: 327

Данжуураас олж мэдсэн байх магадлалтай.²⁷

Занабазар 21 Дар Эхээ бүтээхдээ Нагаржунай ба Атиша нарын уламжлалыг баримталж бүх бурхад нь баруун мутартаа бумба атгасан байдлаар дүрсэлжээ. Нагаржунай болон Атишагийн уламжлалд 6 улаан, 5 цагаан, 7 улбар шар (алтлаг) болон 3 хар нийт 21 Дар-Эх байдаг бол Занабазарын бүтээлүүд бүгд алтадсан баримал тул өөр хоорондоо их төстэй харагддаг²⁸. Ногоон ба Цагаан Дар Эх нь тусгай бүтээлүүд бөгөөд (зураг 7.8) Ногоон Дар Эхийг Экажати (Ekaḥati) болон Маричи (зураг 8) хэмээх 2 дагалдагчтай нь хамтаар бүтээсэн тул нийтдээ 25 Дар Эхийн дүрийг бүтээсэн болно.

Хэрвээ үнэн зөв тогтоосон бол Занабазарын эрэгтэй дүр төрхтэй Маричи нь ("Od ser can ma) тун сонирхолтой²⁹ бөгөөд 5 дэлбээт титэмтэй аж. Ногоон Дар Эхийн дагалдагчийн хувьд түүний баруун талд байрлуулж³⁰ зүүн мутраар сайн үйлс дэлгэрхийг бэлэгдэн (varada mudra), баруун мутраар ном хаялцахыг бэлэгдэн (vitarka mudra) бадамлянхуа цэцгийг атгасан байдлаар дүрсэлжээ.

Фредерик Банс Маричигийн олон хэлбэрийн нэгийг "Бие даасан эмэгтэй дүрт бодисатва" хэмээн тодорхойлсон³¹ хэдий ч энэ дүр нь Жанрайсигийг (Avalokiteśvara) ихээхэн санагдуулж буй. Ийм мөрөндөө гөрөөсний арьс нөмөрсөн эр бие бялдартай Маричи нь Монгол болон Түвдэд ер тааралддаггүй. АНУ-ын Нью-Йорк хотын Рубины музейд хадгалагдаж буй Маричи бол Занабазарын жинхэнэ бүтээл байж болзошгүй тул Богд Хааны Сүм-музейд байгаа Маричи нь нэр усны хувьд мөн эсэхийг дахин нягтлах шаардлага гарч ирж байна (зураг 9).

Балбын хийцийн онцлог нь Занабазар уран барималд давамгайлдаг талаар зураачид дурдсан нь олонтой. Ам дамжиж ирсэн монголчуудын түүх, ярианаас үзэхэд монголчууд Балба, Кашмирийн төмөр хийцийг хамгийн сайнд гооцдог байж.³² Тиймээс Занабазар нь Балбачуудын урлах арга ухааныг Түвдээр дамжуулан авчирсан бус монголчуудын дунд болон Төв Азид аль хэдийнээ хамгийн шилдэг хэмээн алдаршсан уламжлалыг л халж Монголддоо дахин бүтээхийн өөрийн үүрэг гэж үзсэн бололтой.

Түүний өвөг дээдэс болох Хувилай хаан нь Балбын уран дархан Анигег (Anige, 1245–1306) ихэд таашаан дэргэдээ ажиллуулдаг байсныг ч гэрбээр сайн мэдэж байсан нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл, Занабазар өөрийн өвөг дээдсийн үед биширч байсан хэв загварыг сэргээн өнгөрсөн үеийг дахин амилуулан цогцлуулах үүднээс Балбын Невар хийцийг сонирхсон хэмээн дүгнэж болох юм. "Бүх Буддийн үнэний талаар цэц булаалдахуй" хэмээх (Sarvatathagat atattvasamgraha) судар нь Балба дахь буддын шашны гол сургаал мөн. Занабазар Балбын Невар хийцийн хамт Неварын онолын үндсийг хүлээн зөвшөөрсөн хэмээн үзэж болно. Урлаг судлаач

27. Занабазар Түвдөөс 1683 онд захиалсан Ганжуурын хүрэл эх хувиас ганжуурын хоёр бүтэн хуулбарыг бүтээжээ (Ш. Бира 1995: Лувсанпэрэнлэй). Занабазар Дэсэр Санжаа жамцаас (Sde srid Sangs rgyas rgya mtsho) (1653-1705) Данжуурын бүрэн 225 боть захиалж авад, өөрийн 470 шавийн хамт хуулбарлан бүтээжээ. Ш. Бира 1995: Давгажанцан.

26. Хүндэтгэлийн 21 магтаал хэмээх бүтээлийн Вилсоны орчууллага. Гэтэл С. Бэнэр хорин нэгэн Дар Эхийн дүрийг өөр өнгөтэй гэж тодорхойлдог. Түүний үзэж буйгаар хорин нэгэн Дар Эх нь 4 улаан, 6 цагаан, 3 шар, 4 улбар шар, 2 улаан хар, 2 хар Дар Эх байгаа болно.

28. Хүндэтгэлийн 21 магтаал хэмээх бүтээлийн Вилсоны орчууллага. Гэтэл С. Бэнэр хорин нэгэн Дар Эхийн дүрийг өөр өнгөтэй гэж тодорхойлдог. Түүний үзэж буйгаар хорин нэгэн Дар Эх нь 4 улаан, 6 цагаан, 3 шар, 4 улбар шар, 2 улаан хар, 2 хар Дар Эх байгаа болно.

29. Үүнд эргэлзэж байгаа тул дахин судлах хэрэгтэй хэмээн үзэж байна. Энэхүү уран барималын тухай анхны хэвлэл нь Н. Цүлтэм, "Занабазар Монголын гайхамшигтай уран барималч" номонд түвд нэрээр нь "Od ser can ma, эрэгтэй төрхт бурхан гэж тэмдэглэсэн бол (Улаанбаатар, 1982). Бёргер бас энэ бурханы эрэгтэй болохыг дурджээ. Бёргер 1995: 292.

30. Ногоон Дар Эхийн гурвалыг буруу байрлуулсныг (зураг 13) Н.Цүлтэм 1982 онд анх нийтэлжээ.

31. Bunce 1998: 156.

32. Ц.Дамдинсүрэн Монголын зохиолын дээж 100 билиг оршвой (Улаанбаатар, 1959), 109.

Ц.Уранчимэг

Патрисия Бёргерийн хэлсэнчлэн³³ Неварийн дархчууд Өндөр Гэгээнийн хамт Монголдоо буцаж ирэхэд нь Түвдээс дагалдан ирсэн байж болох боловч Балба Неварын уран дархны хийц болон Монголын Их хаадын тэмдэг болсон хээ угалзыг (зураг 13) Монголынхоо эртний уламжлал хэмээн үзэж ийнхүү өөрийн уран бүтээлдээ эрхэмлэсэн байж ч болно.

Занабазарын Цагаан болон Ногоон Дар Эх нь монгол төрхтэй, нүдэнд дулаан тул өөрийн сэтгэлтэй бүсгүйг харж бүтээсэн хэмээх домог ч хүртэл үүсэхэд хүргэсэн боловч батлах баримт байхгүй аж. Түүний Цагаан болон Ногоон Дар Эх нь аль аль нь нүд рүү эгцлэн харахгүй (*darsana*) боловч дотны холбоо мэдрэмж төрүүлдгээр онцлогтой бөгөөд гайхамшигтай³⁴. Занабазар эхнэртэй байсан эсэхийг нотлох баримт байхгүй хэдий ч бурханы шашинтай, шашингүй хүмүүст нэгэн адилаар гүнзгий сэтгэгдэл төрүүлэх Цагаан Ногоон Дар Эхийн онцгой дүр нь үе үеийн монголчуудын сэтгэлд ойр байсаар иржээ.

Очирдарь ба Базарсад

Занабазарын Очирдарь (зураг 10) ба Базарсад (зураг 11) бүтээл нь хутагтын хамгийн том баримлуудын нэг мөн. Түүний шавь Лувсанпэрэнлэйн баталж буйгаар Очирдарь бурхныг багш нь 1683 онд “өөрийн мутраараа” урласан³⁵ гээд харин Базарсадын талаар ямарваа нэг зүйл дурдаагүй байна. Лувсанпэрэнлэйн өгүүлснээр Очирдарь нь Хүрээний амиин зүрх болсон Очирдарийн хийдэд³⁶ хутагтийг жанч халснаас хойш нэлээд хугацаанд байрлаж байгаад ХХ зууны эхээр сүм хийдийг харамсалтайгаар устгасны дараа 1940-өөд онд Ганданд зөөж аваачсан нь эдүгэ Их хүрээнээс эвдэрч гэмтэлгүй орчин цагийг хүрсэн цөөн дурсгалуудын нэг болж үлджээ. Занабазар нь Очирдарийн эрхийн ван хүртсэн гэх бөгөөд хожуу үеийн намтарт дурьдснаар Дувтавжажам (*Sgrub thabs brgya rgyam*) болон Дувтавринченжунай (*Grub thabs rin chen hbyung gnas*) нарын олон лам нараас Очирдарийн номыг сурчээ хэмээн намтарт дурьдсан байна.³⁷

Очирдарь бурхан нь Очир хөлгөний хүрээнд хамгийн дээд байр суурь эзэлдэг агаад нийт “Буддийн шашны Очир хөлгөний оройн дээд” хэмээгдэх тул³⁸ энэхүү гайхамшигт хоёр бурханыг Халх Монголын хойморт залснаар Өндөр Гэгээн Занабазар Очир хөлгөний бие даасан уламжлалыг Монголчуудын дунд дахин бий болгох зорилготой байсныг илэрхийлж буй. Түвдийн Гажидва (*bKa brgyud*) дэг сургуулийнхан Очирдарь бурхныг оройн дээд гэж үздэгийн³⁹ адилаар Занабазар ийнхүү Очирдарь бурхныг залж үүгээр Жавзундамба хутагтууд ч дээд түвшинд залрах үүд нээгдсэн хэмээн үзэж болох юм. Алтан ургийн гаралтай тул дээд язгууртны эрх мэдлийг эдлэж, Очирдарь бурханаа дээд шүтээнээр тахиснаар шашны эрх мэдлийг эзэгнэх боломж нээгдсэн.

Занабазарын Очирдарь нь маш нарийн хийцтэй, гайхамшигтай тансаг уран баримал юм. Занабазарын хийцийн онцлог болох лянхуа цэцэг хүрээлсэн суурин дээр очир суудлаар залж, очир болон хонхыг хоёр мутартаа атгаж арга билгийг бэлэгдэн (*vajra-humkara mudra*) цээжиндээ зөрүүлсэн байдаг. Бурхадаа маш чимхлүүр хийцтэй зүүлт, хээ угалз зэргээр чимж

33. Бёргер 1995: 289.

34. Буддийн шашинтай аялагч Don Croner өөрийн номондоо Цагаан Дар Эхийг харсан тухайгаа бичихдээ: “Би Цагаан Дар Эхийн дэргэд маш хувийн ойр дотно холбоо мэдэрсэн” гэжээ. “Guide to Locales Connected With The Life of Zanabazar: First Bogd Gegeen of Mongolia (Book Surge LLC, North Charleston, 2006).

35. Ш. Бира 1995.

36. Л. Хүрэлбаатар 2001: 171-176.

37. Ш. Бира 1995.

38. Jeff Watt, 2008.

39. Гажидва ёсын Таглуи (*stag lung*) болон Дригун (*'bri gung*) сургуулийн зургуудыг үз. Тухайлбал, Jane Casey Singer, Steven Kossak eds., *Sacred Visions: Early Paintings from Central Tibet* (New York, 1998)

бүтээдгийн нэгэн адил Очирдарийг урласан бөгөөд янз бүрийн чимэг зүүлт, сувдан хэлхээсээр бурханыг чимэглэжээ. Гар хөлийн бугуйвчийг хоёр эгнээ болгон хээ угалз гарган туйлын хичээнгүйлэн бүтээсэн байна. Энэхүү уран баримал нь хэд хэдэн давхар хүзүүний зүүлт, унжлагаар чимэглэгдсэн нь Очирдарь бурханы төгс жаргалангийн биеийг (sambhogakaya) үзэмж төгөлдөр, хараа булаам болгоно. Очирдарь болон Базарсад бурхад нь гаднах үзэмж, хээ угалзын зохимжоор онц ялгарч Занабазарын хамгийн гайхамшигтай, содон бүтээлд тооцогддог. Энэхүү хоёр бурхан хоорондоо салшгүй холбоотой нь тэдний титэмийн хийцээс харагдана. Таван дэлбээг Очирдарийн титэм нь Язгуурын Таван Бурханы дүрийг агуулж Базарсадын титэмийн таван дэлбээнд Язгуурын Таван Бурханы маани (dharani) үсгийг сийлснээр хоёр бурхан холбоотой гэдгийг ийнхүү ойлгомжтой болгожээ.

Өөрийн гэсэн ийм хандлага нь Монголын Их Эзэнт Гүрний үед Сажийнхны оруулж ирсэн туйлын догшин дүрт Жигжид (Vajrabhairava), Гүргомбо (Gur gyi mgon po)⁴⁰ гэх зэрэг бурхад шүтэх номтой адилгүй юм. Монголын Их болон Бага хаадын үед Буддийн шашны дэлгэрэлт зөвхөн язгууртнуудын хүрээнд хязгаарлагдаж байсан бол Занабазар Хүрээ хийдээ Халхын Монголын мөргөлийн төв газар болгохыг хүсч байв. Тэрбээр өөрийн сүм хийдэд байрлуулсан бурхад дүр төрхийг өөрийнхөөрөө сонгон догшин дүртэй бурхад түүний уран бүтээлд байдаггүй нь ийнхүү учиртай юмсанж.

Нүүдэлчдийг нэгтгэх, дотоод хямралыг зогсоож энх амгалант амьдралыг бий болгох, мөн түүнчлэн шашин шүтлэийг хувь хүнд үйлчилхээс гадна нийтийн тусын төлөө болгохын тулд тэрбээр бүтээлээ хийж бурхад дүрээ сонгож байжээ. Хүрээнд Өндөр Гэгээний бүтээсэн найман мөнгөн суварга нь (эдүгэ үрэгдсэн) бурхан багшийн онцгой найман үйлдлийг Их Хүрээнд бэлэгдэн хамааруулж, үүгээрээ Бурхан багшийн мөнхөд орших онцгой хийдийн орчинг бий болгож байлаа. Нөгөөтэйгүүр, Майдар эргэх, гахих ёслол нь ирээдүйн сайн сайхныг бэлэгдэх бөгөөд Аюуш (Amitayus) бурхан нь (зураг 12) ард олон урт удаан наслахыг ерөөн бэлэгдэх учиртай. Хутагтын зааснаар түүний бүтээсэн Аюуш бурхны дүрсэнд Жаплавцогзол зохиолын (Цаг лугаа зохилдуулсан, Адистэдын дээдийг хайрлагч залбирал - Dus bstun gsol 'debs byin glabs mchom stsol ma bzhuqs so) хадаж хавсаргасан гэдэг⁴¹. Ард түмэндээ амар амгалан, энхийг билэгдсэн энэхүү зохиолдоо Занабазар:

Асар дэлгэр номын хурдийг эргүүлэхийг дуртигамуй.

Аугаа орчлон хичнээн үргэлжилтэл эгнэгт баг оршихыг залбирмуй.

Аяа үүгээр жишэн хамаг бүяны цогцсыг

Алимад гурван цагийн бодисатва нарын огоот ерөөсөнчлөн.

Амьтан бүхний булай мунхагийн харанхуй бүхнийг арилгаж.

Ашдын хамгийг айлгагч билгийн гэгээг дэлгэрүүлэхэд зориулмуй гэж бичжээ.

Занабазарын бүтээсэн бурхад нь түүний хэлсэнчлэн "Амьтан бүхний булай мунхагийн харанхуй бүхнийг арилгаж, Ашдын хамгийг айлгагч билгийн гэгээг дэлгэрүүлэхэд зориулмуй" хэмээснээр Монгол оронд бурхны шашны хөгжлийн үрийг суулган дэлгэрүүлж, Жавзундамбын удирдлага дор ард түмнийг нэгтгэх, улс төрийн энх нэгдлийг тогтоох үйлсэд бурхны шашны түүхийг зохируулах эрхэм дээд зорилгыг агуулж байв.

Занабазарын олон бүтээлээс Язгуурын Таван Бурхадыг ард түмэн цэвэрлэгээнд өртөөлгүй

40. Бёреп 1995; 2003: 23-25. Heather Stoddard "A Stone Sculpture of mGur mGonpo.

Mahakala of the Tent, Dated 1292" in *Oriental Art*, n.s., 31, nr 3 (1985) 278-282. Махагал Гүр Гомбо нь XIV зуунд Монголын Их гүрний гол бурхад нэг байжээ. Монголын эзэн хаад, тухайлбал Хувилай хаан тулалдааны үеэр Махагал Гүр Гомбыг урьдаа залснаар дайсныг түргэн ялна хэмээн шүтэж байсан мэдээ байдаг тухай Аннин Жин бичсэн байдаг. Хожим нь Гүр Гомбыг Эрдэнэ Зуу, Төвхөн зэрэг хийдүүдэд шүтэх болсон нь нарийн учиртай юм.

41. Эрдэнэ зуугийн түүх болон Өндөр Гэгээний намтар, Гар бичмэл, 18 дахь хуудас. Монгол Улсын Номын Сан.

Ц.Уранчимэг

авран үлджээ. Түүний ном зохиолоос энх амгалангийн мөргөл буюу Жанлавцогзолыг монголчууд хадгалж үлдсэн нь мөн тохиолдлын зүйл бишээ. Эдгээр бүтээл зохиолууд нь Өндөр Гэгээн өөрийн үүргээ амжилттай гүйцэлдүүлснийг илтгэж байна. Сүсэг бишрэлийн үндэс түгэн тархаж, ард түмнээ нэгтгэх түүний хүсэл ийнхүү биелэгдэж, тэр ч байтугай орчин үед ч ард түмэн нь түүний бүтээлийг өөрийн үндэсний бэлэг тэмдэг, эв нэгдэл, аюулгүй байдлын гол бэлэгдэл хэмээн биширсээр ажгуу.

ABSTRACT

The article "Zanabazar's art and the Building of Buddhist State in Late Medieval Mongolia" examines art of an eminent Mongolian Buddhist artist and scholar Zanabazar (1635-1723) who also was the First Jebtsundamba reincarnate ruler of Mongolia. While some scholars have discussed Zanabazar's art based on stylistic analysis (Tsultem 1982, Berger 1995), the issues of production and the choice of specific forms of deities have remained unclear. The article aims at illuminating Zanabazar's artistic work within his mission of establishing a new Buddhist state in late Medieval Mongolia. Based on his surviving sculptures, his writings, and hagiographies, the article argues that Zanabazar did not consider any sectarian affiliations in his production; rather, he aimed at establishing a foundation for Vajrayana practice with Yoga Tantra deities for propagating Buddhism beyond nobility among broader masses for security and unity of his peoples.

1. Бирузана
2. Акчоба
3. Раднасамбава
4. Амогасидхи
5. Авид
6. 21 Дар Эх
7. Цагаах Дар Эх
8. Ногоон Дар Эх Экажати ба Маричи хоёр дагалдагчийн хамт
9. Рубины Мүзейн дахь Маричи
- 10. Очирдар
11. Базарсад
12. Аюуш
13. Алтан ордоос олдсон аяга

Ц.Уранчимэг



Зураг 1



Зураг 2




Зураг 3



Зураг 4



Зураг 5



Зураг 6



Зураг 7



Зураг 8



Зураг 9



Зураг 10



Зураг 11



Зураг 12



Зураг 13